



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

“Автомашингүй өдөр-2023” нэгдсэн арга хэмжээний зардал гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1109 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Автомашингүй өдөр нэгдсэн арга хэмжээ 2023 оны 09 дүгээр сарын 23-нд зохион байгуулагдах тул Дүүргийн хэмжээний спорт биеийн тамирын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, дүүргээ төлөөлөн оролцуулсугай.


2. Арга хэмжээний зардалд 820,000 (Найман зуун хорин мянга)-н төгрөгийг хавсралтаар баталж, нийтийн биеийн тамирын арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч (П.Бат-Оюун)-нд зөвшөөрсүгэй.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Биеийн тамирын хэлтсийн дарга (С.Сувд)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* Д.ОТГОНСҮРЭН



Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/50 тушаалын хавсралт



ТӨСӨВ

2023 оны 09 дүгээр сарын 20

Улаанбаатар хот

“АВТОМАШИНГҮЙ ӨДӨР” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ

д/д	Арга хэмжээ, нэр төрөл	Нэгж дүн	Мөнгөн дүн	Нийт дүн
1	Үзүүлэх тоглолт	Каратэгийн үзүүлэх тоглолт 100,000	100,000	100,000
2	Хийн дасгал	Хийн дасгал 100,000	100,000	100,000
3	Бусад	Тэмцээний шүүгч 70,000 Тээврийн зардал 70,000 Тараах материал 200,000	Шүүгч 5=5*70,000=350,000 Тээврийн зардал 70,000 Тараах материал 200,000	620,000
		Нийт		820,000